



169

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 12 сарын 30 өдөр

Дугаар Б/132

Ховд

Ж.Саруулыг ажилд томилох тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 50 дугаар зүйлийн 50.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Жавхлантын Саруул нь аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээллийн гэрээт ажилтнаар ажилд орох хүсэлт гаргасан тул 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийг хүртэл томилсугай.

2. Ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.


3. Ж.Саруулыг удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга (Б.Ганболд) -д үүрэг болгосугай.

4. Ж.Саруулыг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтаар баталсан "Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээ"-ний ТҮ-7 дахь зэрэглэлтэй дүйцэхүйц буюу 799806 (долоон зуун ерэн есөн мянга найман зуун зургаа) төгрөгөөр цалинжуулж, холбогдох нэмэгдлийг тухай бүр тооцож олгохыг Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч (Б.Нямдэлгэр)-д зөвшөөрсүгэй.

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Б.БАЯРСҮХ



Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Б/132 дугаар тушаалын хавсралт



АЖИЛ ХҮЛЭЭЛЦЭХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Ганболд (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)

Гишүүд:

Х.Болормаа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын нярав)
Х.Есенкельд (Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэвлэл мэдээлэл, вэб сайт хариуцсан ажилтан)

Нарийн бичиг:

Ц.Лувсанлхамо (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгч)